



БҮГД НАЙРАМДАХ НАМ

REPUBLICAN PARTY

2005 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны сонгуульд Бүгд Найрамдах Намаас нэр дэвшигч УИХ-ын гишүүн, БНН-ын дарга Бээл овогтой Базарсадын Жаргалсайханы мөрийн хөтөлбөрийг дэмжсүгэй.
2. Мөрийн хөтөлбөрийг дэмжсэнтэй холбогдуулан Монголын ард түмэнд таниулж, сурталчилан ажиллахыг нэр дэвшигч болон намын сонгуулийн төв штабд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Т. ЗАНАШИР

ТЭРГҮҮЛЭГЧИД:

Б. ЗОРИГОО

Б. НЯМСҮРЭН

Б. ЭРДЭНЭЦЭЦЭГ

Г. БАТТУЛГА

45

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД
НЭР ДЭВШИГЧ БАЗАРСАДЫН ЖАРГАЛСАЙХАНЫ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**Монголын ард түмний эрх ашигт үйлчлэх нь
Миний эрхмийн дээд хүсэл, зорилго мөн.**

Монгол улсын Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийг эх орныхоо хөгжил дэвшил, ард түмнийхээ сайн сайхан аж амьдралын төлөө хэрэгжүүлэх, улс орны өмнө тулгараад байгаа амин чухал асуудлуудыг хамгийн оновчтой хувилбараар, богино хугацаанд шийдвэрлэхийг эрмэлзсэн бодлого, үзэл баримтлал, үйл ажиллагааныхаа чиглэлийг тусгасан шинэ мөрийн хөтөлбөрөө өргөн олон түмэндээ толилуулж байна.

Монголын төрийн бодлогын нэгдмэл байдлыг хангах үүднээс:

а. УИХ, Засгийн газрын зөв, оновчтой үйл ажиллагааг дэмжих бодлого баримтлах

б. Миний мөрийн хөтөлбөрийг дэмжихэд чиглэгдсэн Улсын Их Хурлын бодлого, Засгийн газрын үйл ажиллагаа нь хөтөлбөр хэрэгжих үндэс, баталгаа нь болох юм.

Төрийн хэрэг залгамжлагдан уламжлагдах шинж чанартайг харгалзан монгол төрийн одоогийн бодлого, үйл ажиллагааны "болж, бүтэж" байгааг нь үргэлжлүүлэх нь зүйтэй тул олон асуудлыг мөрийн хөтөлбөртөө нэг бүрчлэн дэлгэрэнгүй тоочихыг хүссэнгүй. Харин та бидний өмнө гарцаагүй тулгамдаж байгаа асуудлаас шууд эхлүүлбэл зохих дараахь зүйлүүдэд та бүхний анхаарлыг хандуулъя. Үүнд:

Нэг. Урт удаан хугацаагаар үргэлжилж буйн улмаас ард түмнийг туйлдуулан ядрааж, доройтуулж буй 1990 оноос эхтэй "шилжилтийн үе" гэгчийг дуусгахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авах

Хоёр. Улс орны хөгжил дэвшил, ард түмний аж амьдралыг сайжруулах асуудал мухардалд ороод байгаа тул "Монгол орны хөгжлийн нэн хурдац бүхий зөв гарц"-ыг олох

Гурав. Өнгөрсөн 15 жилд төрөөс авч хэрэгжүүлсэн бодлого тэр бүр оновчтой байгаагүйгээс нийтээр хүсэн хүлээсэн үр дүнд хүрсэнгүй. Иймд үр ашиг муутай өнгөрүүлсэн цаг хугацааны алдагдлыг нэн яаралтай нөхөх үйл ажиллагааг явуулж эхлэх.

Дөрөв. Монголын амьдралд одоо тулгараад байгаа асуудлуудыг цэгцэлж, улс төрийн системийн хямралыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авах

Үүний тулд нийгмийн амьдралын бүх хүрээнд бүтээн байгуулалтын эрс шинэчлэл хийх шаардлагатай болж байгаа билээ.

Нэг. Монгол хүн

Монгол улс ардчилал, зах зээлийн харилцаанд шилжээд 15 жил боллоо. Эдгээр он жилүүдэд эрх баригчид олон зүйлийг хийж, хийснээсээ ихийг амалсан хэдий ч ганцхан Монгол хүний төлөө юуг ч үл хийжээ. Өнөөдөр монгол хүн туйлдаж ядарчээ. Монголчууд цөөхөн боловч ухаалаг, оюуны өндөр чадавхитай ард түмэн билээ. Нэг монгол хүний үнэ цэнэ асар өндөр юм. Монгол хүнийг төрийн анхаарлын төвд эргэн оруулж, бүхнийг гагцхүү монгол хүнийхээ төлөө л зориулан монгол хүнийг хайрлах бодлогыг барьж ажиллах болно.

Тэдний амь нас, эрүүл мэндийг хайрлах, хамгаалах асуудал юу юунаас чухал гэж үзнэ.

Бэлчээрийн мал аж ахуй, газар тариалангаас авах эрүүл чанартай хоол, хүнсээр хангах, эрүүл, тав тухтай орчинд амьдарч ажиллах боломжоор хангах зэрэг нь төрийн бодлогын төвд байх учиртай.

Нийслэл Улаанбаатар хотод дэлхийн жишигт хүрсэн эмнэлгийг барьж байгуулан, орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангах, оношлогоо, эмчилгээ, үйлчилгээг эрс шинэчлэн сайжруулах замаар монгол хүний амьд явах баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээг бусад төрлийн үйл ажиллагаатай хослуулан авч хэрэгжүүлэх талаар санаачлагатай ажиллах.

Улаанбаатар хот стратегийн ач холбогдол бүхий байршилтай. Өвөг дээдэс маань зориуд сонгон байршуулж үлдээсэн төрөлх нийслэл хотоо агаарын бохирдол, хорт утаанаас цэвэршүүлж, орчин үеийн цоо шинэ хот болгон өөрчлөх

Бүх монголчууддаа бид боломжийг нь олгоно, та бүтээж чадна гэсэн харилцан итгэлцлийн үндсэн дээр ажиллах, амьдрах урам зоригийг төрийн зүгээс төрүүлэн одоогийнхоос огт өөр зарчмаар амьдрах, ажиллахад чиглэсэн бодлого боловсруулан баримтална.

Ахмадаа дээдлэн халамжилж, туршлага, ухааныг нь төрийн алба, иргэний ахуй амьдралд түгээх санал санаачлага гаргаж хэрэгжүүлэх

Залуучуудаа дотоод, гадаадад боловсрол эзэмших, ажил хөдөлмөр эрхлэхэд бүх талаар туслах, гадаадад ажиллаж, амьдарч, суралцаж буй иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах,

Онцгой авъяас, гоц чадвартныг хайрлан хамгаалж, сургаж боловсруулах, хөгжүүлэх бүхий л зардлыг төр хариуцна. Өндөр хөгжилтэй орнуудад залуучуудыг төрийн сангийн зардлаар, инженер бизнесийн чиглэлээр гэрээгээр сургаж, бэлтгэнэ.

Оюутан залуусын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Монгол хүн бүрийн сэтгэл, зүтгэл, хүчин чармайлт их бүтээн байгуулалт, их амжилтын үндэс болох тул эх нутагтаа болон гадаадын улс орнуудад амьдарцгааж буй нийт монголчуудынхаа их эрч хүчийг нэгтгэн зангидаж, эх орныхоо хөгжил дэвшил, ард түмнийхээ сайн сайхан аж амьдралын эрхэм зорилгод чиглүүлэхэд төрийн бодлого, зохицуулалт оршино.

Хил хязгаарт болон суурин газраас алслагдсан цэргийн анги салбаруудын офицер, ахлагч нарын ажилгүй байгаа гэр бүлийн хүмүүсийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг сайн дурын даатгалын журмаар төр хариуцах.

Шинжлэх ухааны нээлт, соёл урлаг, биөийн тамир, спортын амжилт, эх орноо сурталчлан мандуулах аливаа хэлбэрийг хөхүүлэн дэмжинэ.

47

**Хоёр. Эдийн засгийг хөгжүүлж, бодит өсөлтийг нь
нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн
газраас хэрэгжүүлэх бодлогод
дэмжлэг үзүүлэх талаар**

Ард түмний аж амьдралд их хэмжээгэр бэрхшээл учруулж буй
/ дайсан ч гэж хэлж болох /

- Ажилгүйдэл,
- Ядуурал,
- Авилгал, хээл хахууль
- Үнийн хязгааргүй өсөлтийн дарамт
- Амьд явах болон амьдралын баталгаа алдагдсан зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдтэй тэмцэх

Үүний тулд:

- Ард түмний амьдралыг бодитойгоор дээшлүүлэх,
- Хэт ядуурлаас түргэн гаргах, гудамж талбай, байшингийн орц хонгил, траншөй, хогийн цэгүүд дээр амьдарч аж төрөх явдлыг бүрмөсөн таслан зогсоох

- Бодит орлогыг нь нэмэгдүүлж, худалдан авах чадварыг нь сайжруулах зэрэг арга хэмжээг авах

- Газрын хэвлий дэхь эрдэс баялаг, ашигт малтмал нь Монголын нийт ард түмний өмч тул, түүнийг ашиглах талаар тодорхой хөтөлбөр боловсруулж ажиллах.

- Үндэсний үйлдвэрлэлээ сэргээн, жижиг, дунд үйлдвэрүүдийг олноор барьж, байгуулан хүн амаа ажилтай болгохын хэрээр цалин орлогыг нь нэмэгдүүлэх, цалин орлого нь амьдралд нь хүрэлцэхүйц байх, ингэснээр сэтгэл хангалуун, амар амгалан аж төрөх боломж бололцоог бүрдүүлэх

- Төрийн болон төсвийн байгууллагын ажилтнуудын сарын дундаж **цалингийн хэмжээг 250,0- 350,0 мянгад хүргэх**

- Үйлдвэр байгуулан ажиллуулж эхэлсэн буюу үндэсний үйлдвэрлэлээ сэргээн ажиллуулах талаар бодит санал, санаачлага гаргасан хүмүүсийг төрөөс онцгойлон үзэж, дэмжих

- Орчин үеийн шинэ технологитой үйлдвэр байгуулах, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэргийг төрөөс онцгой анхаарч, түүхий эд, туслах материал, бараа бүтээгдэхүүний зах зээлийг нь татварын болон бусад бодлого, зохицуулалтаар хамгаалан дэмжинэ.

- Бизнесийн хүрээнийхнийг урьд өмнө байгаагүйгээр дэмжин урамшуулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Ингэснээр нэг сайн бизнесмен хэдэн мянган хүний амьдралыг залгуулж авч явах боломж бүрдэнэ гэсэн утгаар бүх төрлийн бизнес эрхлэгчдийг дэмжих төрийн бодлого хэрэгжүүлнэ.

56

Гурав. Төрийн үйл ажиллагааг хэвийн явуулахад чиглэсэн арга хэмжээний талаар

Ардчилсан төрийн хэвийн үйл ажиллагаанд саад тотгор болж, төрийн хүчийг сулруулж буй:

-Төрийн эрх ашгаас урьдчилан намуудын эрх ашиг, сонирхол ноёрхдог

-Намын эрх ашгаар халхавчлагдан хэсэг бүлэг хүмүүсийн ашиг сонирхол хамгаалагддаг

-Төрийн албан тушаалыг хаших чадвар, мэдлэг, туршлагыг үл харгалзан намын бүлэглэл, танил талын шалгуураар томилдог нь албан ажлын эрх ашиг сонирхлыг хохироодог

-Төрийн албыг хаших явдлыг өндөр үүрэг хариуцлага хэмээн ойлгохоос ашиг хонжоо олох аятай таатай нөхцөл хэмээн үздэг

Эдгээрийг арилгаж, төрийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс:

-Намын харъяаллаар ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсоож, гагцхүү мэдлэг мэргэжил, чадвар, туршлагыг харгалзан төрийн албанд томилж байх

-Төрийн албан хаагчид намын гишүүнчлэлгүй болж, зөвхөн төрийн хэргийг нэр төртэй хаших явдлыг чухалчлах.

-Төрийг чадварлаг ажиллуулах, төр нь иргэддээ үйлчилж, Үндсэн хуулинд заасан зарчмыг баримтлан ажиллах нөхцлийг бүрдүүлэх талаар санаачлагатай ажиллах, Төрийн албыг авилгал, хээл хахуулиас цэвэршүүлэх, хүнд суртал чирэгдлийг арилгаж, үйлчилгээний алба утгаар нь ажиллуулахад чиглэсэн арга хэмжээг авна.

-Улс төрийн системийг хямралаас гаргах

-Төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх шатанд олон түмний санал, оролцоог нэмэгдүүлж, олон нийтийн хяналтын тогтолцоо, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажил хэрэгтээ тусгадаг систем бий болгож ажиллах.

Дөрөв. Шүүх засаглалын үйл ажиллагааг эрс шинэчлэх

Энэ салбарт хүний эрх ноцтой зөрчигдөх, хүнд суртал чирэгдэл учруулах, шүүх хуулийн өмнө хүн бүр тэгш байх зарчим алдагдах, шударга бус байдал ноёрхох, авилга, хээл хахуулийн хүчээр ажил бүтээх, ард олон өнгө, мөнгөөр хэмжигдэн ялгаварлан гадуурхагдах зэрэг нь олон түмний сэтгэл зүйд хүнд дарамт болон тусаж байгаа нь шүүх засаглалын үйл ажиллагааг эрс шинэчлэх шаардлага бий болгож байна. Иймд:

Шүүх, шүүх засаглалын байгууллагуудын хараат бус байдлыг хангаж, улс төрийн хүчнүүд, төр засгийн дээд байгууллага, мэдээллийн хэрэгслийн нөлөөнөөс гаргах нь хүн бүр шүүх хуулийн өмнө эрх тэгш байх зарчим хэрэгжих, шүүхийн шийдвэр шударга гарах гол баталгаа болно.

Шүүхийн шинэчлэл хийх гол хүчин зүйлүүд болох

-Эрх зүйн орчинг бүрдүүлэн сайжруулах,

-Мэргэшсэн шүүгчдийг бэлтгэх,

-Санхүү, материаллаг баазыг нь бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тууштай авах төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

-Ажилтнуудын ажиллах болон ахуй амьдралын баталгааг хангах,

-Цалин орлогыг хүрэлцэхүйц хэмжээнд нэмэгдүүлэх,

45

-Бусад хангамж эдлэх асуудлыг төрийн зүгээс шийдвэрлэх нь хээл хахууль, авилгад өртөхгүй байх хүчин зүйлд тооцогдоно хэмээн үзнэ.

-Хууль хамгаалах байгууллагын тогтолцоог боловсронгуй болгох,

-Төрийн тусгай албан хаагчдын үйл ажиллагааны баталгааг сайжруулах, улс төрийн намуудын эрх ашиг сонирхлоос хамааралтай удирдах ажилтнууд, төрийн тусгай албан хаагчид байнга өөрчлөгдөн солигдож байдаг одоо тогтоод байгаа зуршлыг халах

Тав. Хүний эрх

Монгол улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг ханган хэрэгжүүлэхэд төрийн бодлого, үйл ажиллагаа чиглэгдэх болно. Хүний эрхийн үндсэн тулгуур зарчмууд болон төр иргэнийхээ өмнө хариуцлага хүлээх зарчмыг бодитой хэрэгжүүлэх

Хүний эрх дотроос ихээхэн зөрчигдөж буй эрх бол Иргэдийн хөдөлмөрлөх эрх гэж үзэж буй тул 35-45, түүнээс дээш насны хөдөлмөрийн чадвар бүхий хүмүүсийг ажлын байраар хангахад илүү анхаарч, ажил хөдөлмөр эрхлэх эрхээ хэрэгжүүлэхэд онцгой анхаарал хандуулах

55-60 настай түүнээс дээш насны хадалмөрийн чадвар бүхий иргэдийг хуульд заасан эрхээ эдлэх боломжоор хангах замаар залуу дунд, ахмад үеийн холбоог сайжруулан, тэдний амьдралын арвин туршлага, мэдлэгийг өвлүүлэхэд чиглэсэн бодлогыг чухалчилна.

Зургаа. Үндэсний аюулгүй байдлыг хангах

Батлан хамгаалах болон хилийн цэргийн бүтцийг боловсронгуй чадварлаг болгож, олон талын гүйцэтгэх чадварыг сайжруулж, олон улсын алан хядлагатай хийх тэмцлийн хүрээнд энхийг сахиулах ажиллагаанд оролцоно.

Долоо. Гадаад бодлогын хүрээнд

Монгол улсын гадаад бодлогын уламжлалт чанарыг хадгалж, улс төр, эдийн засгийн нээлттэй бодлогыг барьж, тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, улс орныхоо язгуур эрх ашгийг улс төр дипломатын аргаар хангана.

БАЗАРСАДЫН ЖАРГАЛСАЙХАН